

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/03/НА-ТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: [narmandakhts@audit.gov.mn](mailto:narmandakhts@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

Аудитор: Б.Пүрэвсүрэн  
Утас: 70353717 Цахим хаяг: [dalaivan.orkhon@gmail.com](mailto:dalaivan.orkhon@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.24 № 82  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ Х.ТӨГСБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн харьяалал, бүтцэд өөрчлөлт орсноор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А-1/1827 дугаар тогтоолын дагуу "Хангайн бүсийн арга зүйн төв" татан буугдаж 212,902.54 мянган төгрөгийн 44-н нэр төрлийн 106 ширхэг тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч бүртгэлд тусгасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар 24-ны өдрийн 284 дугаар тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 642,497.66 мянган төгрөгийн 23-н нэр төрлийн 41 ширхэг тоног төхөөрөмжийг хүлээн авч бусад үндсэн хөрөнгө дансанд тусгасан байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлангийн хугацаанд улсын төсвөөс 1,856,537.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 359,620.1 мянган төгрөг нийт 2,216,157.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 2,097,809.2 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, 118,348.0 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудиторт аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 443 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
Ц.НАРМАНДАХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>399,059,592.51</b>	<b>412,461,744.87</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,938,028.16	5,300,000.00
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	4,938,028.16	5,300,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,938,028.16	5,300,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,938,028.16	5,300,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	852,935.00	508,289.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	462,935.00	477,496.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	390,000.00	30,793.52
3351	Байгууллагаас авах авлага	390,000.00	30,793.52
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	393,268,629.35	406,653,455.35
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	331,011,705.85	335,437,440.85
35110	Тусгай зориулалттай материал	330,247,205.85	334,672,940.85
35130	Эм боох материал	764,500.00	764,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	20,272,724.50	22,593,724.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	41,984,199.00	48,622,290.00
35410	Бичиг хэргийн материал	171,140.00	2,540,510.00
35420	Аж ахуйн материал	7,917,999.00	22,746,640.00
35450	Барилгын засварын материал	19,580,890.00	16,879,940.00
35460	Хүнсний материал	11,373,520.00	3,514,550.00
35470	Бусад хангамжийн материал	2,940,650.00	2,940,650.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,446,886,392.79</b>	<b>10,049,974,195.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	9,446,886,392.79	10,049,974,195.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	8,670,503,312.98	9,276,534,195.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,453,870,210.00	8,453,870,210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-641,230,473.86	-794,588,950.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79,760,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-79,760,000.00	-5,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,268,720,421.26	2,481,622,963.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,498,718,834.27	-1,621,470,202.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	191,271,494.88	254,667,925.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	-162,896,088.94	-168,923,537.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	642,497,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-36,465,241.28
39217	Ном	59,486,583.91	65,323,367.91
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	776,383,079.81	773,440,000.00
39301	Программ хангамж	38,708,261.40	38,708,261.40
39302	Хуримтлагдсан элэгдэл	-35,765,181.59	-38,708,261.40
39303	Бусад биет бус хөрөнгө	773,440,000.00	773,440,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>9,845,945,985.30</b>	<b>10,462,435,940.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,819,038.00</b>	<b>35,784,095.56</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,819,038.00	35,784,095.56
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,363,849.00	35,784,095.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	19,924,604.56
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	39,450.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,363,849.00	15,820,041.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,260,145.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	103,704.00	15,820,041.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	5,455,189.00	00.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	5,455,189.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,838,126,947.30</b>	<b>10,426,651,844.47</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	9,838,126,947.30	10,426,651,844.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,609,363,524.31	2,609,363,524.31

51101	Өмч: - төрийн	1,835,923,524.31	1,835,923,524.31
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	773,440,000.00	773,440,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,323,384,638.01</b>	<b>4,911,909,535.18</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	4,323,384,638.01	4,328,839,827.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	583,069,708.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,905,378,784.98	2,905,378,784.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,845,945,985.30</b>	<b>10,462,435,940.03</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,398,427,466.20</b>	<b>3,199,607,807.32</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>732,418,166.20</b>	<b>3,191,407,807.32</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>107,639,615.00</b>	<b>975,250,607.32</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	750,000.00	945,413,227.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	750,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	945,413,227.32
120005	Түрээсийн орлого	21,100,985.00	00.00
120009	Бусад орлого	85,788,630.00	29,837,380.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>624,778,551.20</b>	<b>00.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	624,778,551.20	00.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>2,216,157,200.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,856,537,100.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	359,620,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,666,009,300.00</b>	<b>8,200,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,666,009,300.00</b>	<b>00.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,666,009,300.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>8,200,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,200,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,100,381,414.84</b>	<b>2,616,538,099.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,100,381,414.84</b>	<b>2,616,538,099.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,921,218,137.91</b>	<b>2,349,418,148.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,121,118,255.54</b>	<b>1,415,033,431.29</b>
210101	Үндсэн цалин	1,073,926,290.54	1,329,678,874.29
210102	Нэмэгдэл	1,624,365.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,567,600.00	85,354,557.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>146,938,196.00</b>	<b>177,365,820.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	103,777,554.00	122,731,427.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,159,788.00	14,021,216.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,927,830.00	11,216,970.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,086,061.00	2,645,844.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,986,963.00	26,750,363.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>103,889,794.46</b>	<b>104,659,606.89</b>

210301	Гэрэл, цахилгаан	14,841,979.30	17,907,558.15
210302	Түлш, халаалт	65,504,939.68	65,693,874.42
210303	Цэвэр, бохир ус	23,542,875.48	21,058,174.32
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>71,114,837.51</b>	<b>25,076,716.00</b>
210401	Бичиг хэрэг	3,582,830.00	3,616,880.00
210402	Тээвэр, шатахуун	4,083,748.00	2,965,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,167,872.91	2,723,485.42
210404	Ном, хэвлэл	57,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,619,100.00	5,717,200.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,684,364.30	10,054,150.00
210408	Бараа материал акталсны зардал	20,919,722.30	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,718,360.00</b>	<b>58,059,405.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,225,000.00	1,972,200.00
210502	Хоол, хүнс	32,233,360.00	56,087,205.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,991,300.00</b>	<b>102,231,089.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	475,000.00	27,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	251,000.00	2,162,500.00
210604	Урсгал засвар	22,265,300.00	100,041,389.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>250,400.00</b>	<b>2,102,250.00</b>
210702	Дотоод албан томилолт	250,400.00	2,102,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,037,700.00</b>	<b>19,108,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,580,300.00	8,465,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,752,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,100,000.00	6,940,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.00	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	42,500.00	42,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,242,400.00	1,833,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,500.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>398,159,294.40</b>	<b>445,781,729.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,846,800.00	125,957,857.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	353,292,494.40	319,823,872.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>179,163,276.93</b>	<b>267,119,951.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>149,401,797.30</b>	<b>148,743,448.16</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,385,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,254,297.00	69,522,941.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	103,471,500.00	67,256,420.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,676,000.30	10,578,787.16
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,761,479.63</b>	<b>118,376,502.86</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,761,479.63	118,376,502.86
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>298,046,051.36</b>	<b>583,069,708.17</b>

<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	79,106.67	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	79,106.67	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-79,106.67	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>297,966,944.69</b>	<b>583,069,708.17</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,772,933,397.00</b>	<b>2,254,194,580.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>106,889,615.00</b>	<b>2,245,994,580.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	106,889,615.00	29,837,380.00
120005	Түрээсийн орлого	21,100,985.00	00.00
120009	Бусад орлого	85,788,630.00	29,837,380.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	00.00	2,216,157,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,856,537,100.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	00.00	359,620,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,666,043,782.00</b>	<b>8,200,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,666,009,300.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,666,009,300.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	8,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,200,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	34,482.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	34,482.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,768,010,968.84</b>	<b>2,260,476,013.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,768,010,968.84</b>	<b>2,260,476,013.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,588,813,210.21</b>	<b>2,009,071,662.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,118,223,777.72	1,414,998,975.25
210101	Үндсэн цалин	694,512,406.93	864,800,960.73
210102	Нэмэгдэл	311,323,513.79	380,682,214.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,190,456.00	83,713,765.00
210104	Урамшуулал	65,197,401.00	85,802,035.09
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	147,821,760.12	166,061,280.00
210201	Тэтгэврийн даатгал	103,559,774.00	118,698,103.39
210202	Тэтгэмжийн даатгал	11,448,733.93	11,845,599.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,058,186.93	9,476,439.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,153,472.83	2,367,412.44
210205	Эрүүл мэндийн даатгал	21,601,592.43	23,673,724.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	103,889,794.46	104,659,606.89
210301	Гэрэл, цахилгаан	14,841,979.30	17,907,558.15
210302	Түлш, халаалт	65,504,939.68	65,693,874.42
210303	Цэвэр, бохир ус	23,542,875.48	21,058,174.32
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,189,620.91	36,671,351.00

210401	Бичиг хэрэг	3,421,500.00	5,831,065.00
210402	Тээвэр, шатахуун	3,260,000.00	2,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,167,872.91	2,723,485.42
210404	Ном, хэвлэл	57,200.00	1,089,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,396,600.00	5,474,000.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,886,448.00	18,753,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>74,156,305.00</b>	<b>53,767,300.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,225,000.00	1,972,200.00
210502	Хоол, хүнс	43,971,705.00	46,500,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,959,600.00	5,294,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,293,450.00</b>	<b>112,066,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	720,000.00	4,072,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,150,000.00	10,393,400.00
210604	Урсгал засвар	31,423,450.00	97,601,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>250,400.00</b>	<b>2,102,250.00</b>
210702	Дотоод албан томилолт	250,400.00	2,102,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,060,200.00</b>	<b>19,108,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,399,300.00	8,465,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,752,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,100,000.00	6,940,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.00	75,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	42,500.00	42,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,453,400.00	1,833,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,927,902.00</b>	<b>99,635,899.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,927,902.00	99,635,899.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>179,197,758.63</b>	<b>251,404,351.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>149,401,797.00</b>	<b>133,027,848.16</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,385,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,937,797.00	53,702,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	87,251,500.00	67,246,520.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,212,500.00	10,693,128.16
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,795,961.63</b>	<b>118,376,502.86</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,795,961.63	118,376,502.86
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,922,428.16</b>	<b>-6,281,433.16</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>4,922,428.16</b>	<b>-6,281,433.16</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>15,600.00</b>	<b>4,938,028.16</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,938,028.16</b>	<b>5,300,000.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.31	2,905,378,784.98	4,526,471,775.39	10,041,214,084.68
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,609,363,524.31	2,905,378,784.98	4,526,471,775.39	10,041,214,084.68
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-377,422,705.38	-377,422,705.38
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.31	2,905,378,784.98	4,323,384,638.01	9,838,126,947.30
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.31	2,905,378,784.98	4,323,384,638.01	9,838,126,947.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,455,189.00	5,455,189.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,609,363,524.31	2,905,378,784.98	4,328,839,827.01	9,843,582,136.30
8	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	583,069,708.17	583,069,708.17
9	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,609,363,524.31	2,905,378,784.98	4,911,909,535.18	10,426,651,844.47

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,630,700.00	337,908,689.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,630,700.00	337,908,689.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,159,900.00	313,197,059.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,773,700.00	244,892,295.00
210101	Үндсэн цалин	188,028,000.00	123,167,598.00
210102	Нэмэгдэл	79,500,000.00	86,587,350.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,203,500.00	18,154,800.00
210104	Урамшуулал	20,042,200.00	16,982,547.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,346,700.00	20,154,741.00
210201	Тэтгэврийн даатгал	25,395,800.00	13,866,611.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,987,700.00	1,631,365.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,390,200.00	1,278,212.39
210204	Ажилгүйдлийн даатгал	597,500.00	302,682.87
210205	Эрүүл мэндийн даатгал	5,975,500.00	3,075,868.76
2104	Хангамж, бараа материалын зардал	4,333,200.00	4,332,030.00
210401	Бичиг хэрэг	559,300.00	338,100.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	1,250,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,267,500.00	474,630.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,343,100.00	1,136,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	663,300.00	1,132,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,527,400.00</b>	<b>636,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,400.00	00.00
210502	Хоол, хүнс	10,500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	954,000.00	636,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,687,000.00</b>	<b>5,672,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,687,000.00	5,672,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,250,000.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,330,900.00</b>	<b>5,598,493.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,280,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,500,000.00	5,498,493.40
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	42,500.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	333,400.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31911000.00</b>	<b>31911000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,911,000.00	31,911,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28470800.00</b>	<b>24711630.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,470,800.00</b>	<b>24,711,630.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,470,800.00	24,711,630.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>4,938,028.16</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>213,778,025.76</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1,020.00</b>	<b>58,301.00</b>
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00

## Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,631.81 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,271.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 160.86 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 20,199.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 1. Төлбөрийн акт

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болгосон ажилтанд ажилласан хугацааны цалинг олгосноос гадна 1,271.5 мянган төгрөгийн тэтгэмж тусламж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

## **2. Албан шаардлага**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 талбарын мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3.-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
2. Давхар ажил эрхэлсэн ажилтны цалинг тооцохдоо хөнгөлөлтийг давхар тооцож 160.8 мянган төгрөгийн татварыг дутуу тооцсон. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ; Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ 240,000 төгрөг" гэсэн хэсэг зөрчигдсэн байна.

## **3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Томилолтын зардлыг тооцохдоо 192.0 мянган төгрөгийн мөнгийг илүү тооцож олгосон мөн томилолтын зардалд 52.0 мянган төгрөгийн хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин "давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх" Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" зэрэг хууль тогтоомжуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллах.

### **2. Авлага өглөгийн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлангийн хугацааны эцэст 508.29 мянган төгрөгийн авлага 19,924.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Тайлангийн хугацааны эцэст авлага өглөгийн үлдэгдэлгүй байх

### **3. Хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд ашиглагдахгүй актлах болон ашиглагдаж байгаа цаашид ашиглагдах элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй 443 ширхэг хөрөнгө байна.

Энэ нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийг бодитоор бүртгэж тайлагнах .

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон ажилтанд ажилласан хугацааны цалинг олгосноос гадна нь тэтгэмж тусламж олгосон байна.	1	1,271.5	1	1,271.5								
Давхар ажил эрхэлдэг хүний цалинг тооцохдоо ХХОАТ-ыг суутган тооцоогүй байна	1	160.8			1	160.8						
Томилолтын зардлыг тооцохдоо илүү тооцож хувь хүний сугалаатай баримтаар гүйлгээ хийсэн байна.	1	244.0					1	244.0				
Тайлангийн хугацааны эцэст авлага, өглөгийн үлдэгдэлтэй байна.	1	19,955.3					1	19,955.3				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>21,631.8</b>	<b>1</b>	<b>1,271.5</b>	<b>1</b>	<b>160.8</b>	<b>2</b>	<b>20,199.3</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 талбарын мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	1	1			1			